



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2020 оны 08 сарын 26 өдөр

Дугаар 854

Улаанбаатар хот

Банк бус санхүүгийн байгууллага,
хадгаламж, зээлийн хоршоодод
авах арга хэмжээний тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 8 дугаар зүйлийн 8.2, Монгол Улсын Их хурлын 2020 оны “Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын үед санхүү, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн үйлчилгээнд цахим шилжилт хийх арга хэмжээний тухай” 32 дугаар тогтоолын 2.5, Монгол Улсын Их Хурлын 2006 оны 45 дугаар тогтоолоор баталсан “Санхүүгийн зохицуулах хорооны дүрэм”-ийн 2.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Сангийн сайдын 2015 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн 144/125 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Банк бус санхүүгийн байгууллагын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-ын хавсралтын Зээл, факторингийн хугацааны үзүүлэлт, 145/124 дүгээр хамтарсан тушаалаар баталсан “Хадгаламж, зээлийн хоршооны активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-ын хавсралтын Зээл, санхүүгийн түрээсийн хугацааны үзүүлэлтийн ангиллыг тус тус 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуусталх хугацаанд дор дурдсан байдлаар ангилж ажиллахыг банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж, зээлийн хоршоодын гүйцэтгэх удирдлагад үүрэг болгосугай.

Ангилал	Хэвийн	Хугацаа хэтэрсэн	Хэвийн бус	Эргэлзээтэй	Муу
Хугацааны үзүүлэлт	Үндсэн төлбөр, хүүгийн эргэн төлөлт, хуваарьт заасан хугацаандаа хийгдэж байгаа буюу 90 хоног хүртэл хугацаа хэтэрсэн	Үндсэн төлбөр, хүүгийн эргэн төлөлт хийгдэлгүй хуваарьт заасан хугацаанаас 91-150 хүртэл хоног хэтэрсэн	Үндсэн төлбөр, хүүгийн эргэн төлөлт хийгдэлгүй хуваарьт заасан хугацаанаас 151-240 хүртэл хоног хэтэрсэн	Үндсэн төлбөр, хүүгийн эргэн төлөлт хийгдэлгүй хуваарьт заасан хугацаанаас 241-360 хүртэл хоног хэтэрсэн	Үндсэн төлбөр, хүүгийн эргэн төлөлт хийгдэлгүй хуваарьт заасан хугацаанаас 361-ээс дээш хоног хэтэрсэн

2. Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Сангийн сайдын 2015 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн 144/125, 145/124 дүгээр хамтарсан тушаалаар тус тус баталсан “Банк бус санхүүгийн байгууллагын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-ын 2.4 дэх заалт, “Хадгаламж, зээлийн хоршооны активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж,

зарцуулах журам"-ын 2.4 дэх заалт, тэдгээрийн хавсралтын “Зээл, факторингийн хугацааны үзүүлэлтийг дүгнэх хүснэгт”, “Зээл, санхүүгийн түрээсийн хугацааны үзүүлэлтийг дүгнэх хүснэгт”-ийн үйлчлэлийг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх хугацаанд түр зогсоосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай

ДАРГА  Д.БАЯРСАЙХАН

